



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

**“Нээлттэй хаалганы өдөрлөг”
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн санал, хүсэлтийг бодлого шийдвэрт тусгах, иргэдийг ажлын байранд зуучлах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 2 дугаар хорооны Хөл бөмбөгийн талбайд зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

2.“Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар, шаардагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тус арга хэмжээнд зарцуулагдах 396,750 (Гурван зуун ерөн зургаан мянга долоон зуун тавь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Аж ахуйн нэгж, байгууллагууд оролцоогоо бүрэн ханган оролцож, иргэдээс гарсан санал, санаачилгыг ажил хэрэг болгон үйл ажиллагаандаа тусгаж ажиллахыг Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт даалгасугай.


5.Дээрх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хяналт тавьж, үр дүнг тооцон, эргэн танилцуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 дүгээр сарын 08 ны өдрийн
111/24 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ” ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго:

“Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх” жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нутгийн захиргааны байгууллага болон үйлдвэр, аж нэгжүүдийн үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, тайлбарлан таниулах, иргэдийн санал хүсэлтийг сонсон, бодлого шийдвэрт тусгахад оршино.

Зорилт:

1. Дүүргийн нутгийн захиргааны байгууллага бүр явуулж буй бодлого, чиглэл, үйл ажиллагаагаа оршин суугч иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сурталчлан мэдээлэх
2. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, компаниуд ажлаа иргэд олон нийтэд сурталчлан, дүүргийн иргэдийг ажлын байранд зуучлах
3. Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг сонсох, тулгамдаж буй асуудлыг газар дээр нь шийдвэрлэх, санал хүсэлтийг дүүргийн бодлого шийдвэрт тусгах
4. Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журмыг иргэдэд таниулан, сурталчлах

Хамрах хүрээ: Дүүргийн нутгийн захиргааны байгууллага болон дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд

Хугацаа, байршил:

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 11.00-15.00 цагт Багахангай дүүргийн 2-р хорооны хөл бөмбөгийн талбайд


Оролцогч байгууллагууд:

- Засаг даргын Тамгын газар
- Шүүх, прокурорын байгууллага
- Цагдаагийн хэлтэс
- Онцгой байдлын хэлтэс
- Татварын хэлтэс
- Нийгмийн даатгалын хэлтэс
- Улсын бүртгэлийн хэлтэс
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
- Эрүүл мэндийн төв
- Газар зохион байгуулалтын алба
- Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк НӨҮГ

- Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв
- “Синво юань” ХХК
- “Хангайнган-Эрдэнэ” ХХК
- “Монгол 8888” ХХК
- “Трансгайд сервис” ХХК
- “Ян сарьдаг Оргил” ХХК
- “Эл эс рэйлвэй” ХХК
- “Тен агро” ХХК
- “Хангайн Хан Өндөр” ХХК
- “Эрдэс плазм” ХХК
- “Орика Монгол” ХХК
- “Мера” ХХК
- “Тес петролиум” ХХК
- “Амарсанаа степ” ХХК
- “Агар эрдэс шохой” ХХК
- “Кемекс” ХХК
- “Багахангай сүү” ХХК

9.	Аж ахуйн нэгж байгууллагын танилцуулга	“Эрдэс плазм” ХХК	12.20-12.25	Аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрх бүхий албан тушаалтан
		“Орика Монгол” ХХК	12.25-12.25	
		“Мера” ХХК	12.25-12.30	
		“Тес петролиум” ХХК	12.30-12.35	
		“Амарсанаа степ” ХХК	12.35-12.40	
		“Агар эрдэс шохой” ХХК	12.45-12.50	
		“Кемекс” ХХК	12.50-12.55	
		“Багахангай сүү” ХХК	12.55-13.00	
10.	Ая дууны мэндчилгээ	13.00-13.05	Соёлын ордон	

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 дүгээр сарын 09 ны өдрийн
11/198 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ” АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХӨТӨЛБӨР**

№	Үйл ажиллагааны дараалал	Хугацаа	Хариуцах эзэн	
1.	Оролцогчдыг бүртгэх, аж ахуйн нэгж, байгууллагыг зураглалын дагуу байрлуулах	10.00-11.00	ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Гэрэлцолмон	
2.	Үйл ажиллагааг нээх	11.00-11.10	Засаг дарга А.Сүхболд	
3.	Багахангай дүүргийн танилцуулга (шторк)	11.10-11.15	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Батболд	
4.	Ая дууны мэндчилгээ	11.15-11.20	Соёлын ордон	
5.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээлэл (шторк)	11.20-11.25	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	
6.	Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк НӨҮГ-ын танилцуулга	11.25-11.30	Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк НӨҮГ-ын дарга Ц.Жамбалцэрэн	
7.	Аж ахуйн нэгж байгууллагын танилцуулга	“Синво юань” ХХК	11.35-11.40	Аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрх бүхий албан тушаалтан
		“Хангайнган-Эрдэнэ” ХХК	11.40-11.45	
		“Монгол 8888” ХХК	11.45-11.50	
		“Трансгайд сервис” ХХК	11.50-11.55	
		“Ян сарьдаг Оргил” ХХК	11.55-12.00	
		“Хангайн Хан Өндөр” ХХК	12.00-12.05	
		“Тен агро” ХХК	12.05-12.10	
	“Эл эс рэйлвэй” ХХК	12.10-12.15		
8.	Ая дууны мэндчилгээ	12.15-12.20	Соёлын ордон	

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 дүгээр сарын 28 ны өдрийн
1198 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ” АРГА ХЭМЖЭЭНД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Анонс (ААНБ-ын нэр) нэг ширхэг нь 2,9*0,4	м2	1.16*10= 11,6	20,000	232,000
2	Тайз, дэлгэц зөөвөрлөх (Түлш)	л	30	3500	105,000
3	1, 2-р хорооны иргэдийг зөөвөрлөх	л	25	2390	59,750
	Нийт дүн:				396,750